



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1/03

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1630 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1630 дугаар захирамжийн дагуу төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороонд байрлах Дүүргийн соёлын ордны барилгын ажилд нэмэлт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Лхагважав)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Баярхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний  
өдрийн 2/03 дугаар тушаалын хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.ЛХАГВАЖАВ

(НХОГ-ын Зураг төслийн  
хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

А.ЭРДЭНЭМӨНХ

(Нийслэлийн Засаг даргын  
Тамгын газрын Эдийн засгийн  
хөгжил, төр, хувийн хэвшлийн  
түншлэлийн хэлтсийн Хөрөнгө  
оруулалтын санхүүжилтийн эх  
үүсвэр хариуцсан мэргэжилтэн)

Д.ПҮРЭВЖАВ

(НХОГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн  
Хөрөнгө оруулалтын санхүүжилт  
хариуцсан Ахлах мэргэжилтэн)

Ц.БЯМБАЖАВ

(Баянгол дүүргийн 5 дугаар  
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Ч.БАЯРХҮҮ

(НХОГ-ын Барилга  
захиалагчийн хэлтсийн  
Барилгын хяналтын инженер)